

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 7-р сарын 04-ны байдлаар


2018 оны 7-р сарын 4-ний байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 4.6 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.7 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 7-р сарын 4-ний байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 0.8, үхрийн ястай махны үнэ 4.9 хувь, үхрийн цул махны үнэ 3.3 хувь, ямааны ястай махны үнэ 3.1 хувь, адууны ястай махны үнэ 5.2 хувиар тус тус өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.4 хувь, үхрийн ястай махны үнэ 1.4 хувь, үхрийн цул махны үнэ 1.4 хувь, адууны ястай махны үнэ 3.7 хувиар өссөн бол ямааны ястай махны үнэ 0.3 хувиар буурсан байна.

2018 оны 7-р сарын 4-ний байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7575 төгрөг, үхрийн /ястай/ мах 9160 төгрөг, үхрийн цул мах 10880 төгрөг, адууны /ястай/ мах 6600 төгрөг, ямааны /ястай/ мах 5350 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2018 оны 7-р сарын 4-ний савласан дээдийн дээд гурилын үнэ өмнөх сараас 1.6 хувь, савласан дээд гурилын үнэ 0.9 хувь, савласан 2-р зэргийн гурилын үнэ 0.1 хувиар өсөж, задгай 1-р зэргийн гурилын үнэ 0.7 хувир буурсан байна. Гурилын үнийг өмнөх 7 хоногтой харьцуулахад савласан дээдийн дээд гурилын үнэ 0.9 хувь, савласан дээд гурилын үнэ 1.9 хувиар өссөн байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 7-р сарын 4-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос 2.5 хувиар буурсан, элсэн чихрийн үнэ өмнөх сараас 2.7 хувь, өмнөх 7 хоногоос 1.9 хувиар буурсан байна (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 7-р сарын 4-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 21.7 хувь, хүрэн манжингийн үнэ 23.3 хувь, луувангийн үнэ 16.0 хувь, байцааны үнэ 15.3 хувиар өссөн байна. Харин сонгины үнэ 0.1 хувиар буурсан байлаа.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ 4.3 хувь, луувангийн үнэ 2.0 хувь, байцааны үнэ 15.8 хувь, хүрэн манжингийн үнэ 1.4 хувиар буурсан бол сонгины үнэ 3.8 хувиар өссөн байлаа.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 7-р сарын 4-ний байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 2.8 хувь, задгай сүүний үнэ 20.2 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.6 хувиар буурсан байлаа. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 1.3 хувь, задгай сүүний үнэ 15.0 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.9 хувиар буурсан байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас 2.3 хувь, өмнөх 7 хоногоос 1.0 хувиар буурсан байна. Цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байлаа.